



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/71

Баянбулаг

Дэлгэрэх 2 дугаар багийн төвийн засварын  
ажлыг хүлээн авах ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн Дэлгэрэх 2 дугаар багийн төвийн засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Амгаланбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Ж.Уламбадрах (Дэлгэрэх 2-р багийн засаг дарга)

Г.Түмэнболд (Нягтлан бодогч)

Т.Одмаа (Орон нутаг хариуцсан нягтлан бодогч)

Б.Баярт-Од (Иргэний төлөөлөл)

2.Гэрээнд заасны дагуу Дэлгэрэх 2 дугаар багийн төвийн засварын ажлыг чанартай гүйцэтгэсэн эсэхийг хянан ажил хүлээлцсэн акт, бусад холбогдох баримт бичгийг бүрдүүлэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.



ДАРГА Н.ГАНСҮХ

642201067